

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэнон ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Дасгал ажил 1. Мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх

Мэдрэмж: Харах, үнэрлэх, сонсох, амтлах, хүрэлцэх таван мэдрэхүйд мэдрэгдсэнийг үгээр илэрхийлэхийг хэлнэ.

Сэтгэгдэл: Тухайн зүйлийг анх харахад төрсөн мэдрэмж буюу тэр мэдрэмжээ хэрхэн хүлээн авч буйгаа өөрийн үгээр шууд илэрхийлэхийг хэлнэ.

Үзэл бодол: Баримт сэтгэгдэл хоёрын завсарт орших бөгөөд **мэдлэг, мэдээлэлд тулгуурлан оюун дүгнэлт хийхийг хэлнэ.**

Алхам 1: Мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэгийг олж дуугуйлна. Доорх цэгийн оронд бодит юм, үзэгдлийг ялгаж бичнэ. Мэдрэмж сэтгэгдлээ ямар үг хэллэгээр илэрхийлснийг тодорхойлно. **Үлгэрлэвэл:** Өргөн Сэлэнгэ минь хүчтэй байна.

Өргөн

Сэлэнгэ минь

хүчтэй байна.

Бодит юм: Сэлэнгэ **Мэдрэмж сэтгэгдлээ ямар үгээр илэрхийлсэн:**
өргөн – тэмдэг нэрээр, **хүчтэй** – тэмдэг нэрээр

- Толгод хөтөлсөн нүүдэл нь
Бодолтой минь дэндүү адилхан
Тооройн шаргал говь минь
Ижийтэй минь дэндүү ижилхэн (Ш.Г)
Бодит юм, үзэгдэл нь **Ямар үгээр**
- Ачаа нь тэнцүүлсэн нүүдэл нь
Амьдралтай минь дэндүү адилхан
Адууны чимээтэй тал минь
Жаргалтай минь дэндүү ижилхэн (Ш.Г)
Бодит юм, үзэгдэл нь **Ямар үгээр**
- Хээр замын хажууд
Тулгын гурван чулуу байна.
Хэний ч юм бэ асаасан
Галын жаахан үнс байна. (До.Ня)
Бодит юм, үзэгдэл нь **Ямар үгээр**
- Миний дэлхийн чулуунууд
Дэргэд “элдэг” бага нас
Миний дэлхийн чулуунууд
Дэлхийдээ “өтөлдөг” их нас (Б.Л)
Бодит юм, үзэгдэл нь **Ямар үгээр**
- Нутгийн чулуу нь цас бороотой халтартан уйлж, өвөөгийн минь шарил дээгүүр билүүн нулимс дусаадаг юм. (Ж.Л)
Бодит юм, үзэгдэл нь **Ямар үгээр**

Алхам 2: Мэдрэмж сэтгэгдэл илэрхийлсэн хэсгүүдийг өнгөөр ялган будаарай. Хэсгүүдийг эвлүүлж нэгэн эх бүтээнэ үү. Зохиолч Д.Батбаяр “Жоконда” – гийн нууц



Мэдрэмж сэтгэгдэл ?

Чухамхүү гэгээн гуниг гэдэг энэ л байх.

толгой дээгүүрээ хэдэрсэн сиймгэр хар нөмрөг, энгэр захгүй олон хуниаст хар хүрэн даашинз өмссөн нь

зөвхөн нүүр царай болоод хүзүү цээж, гараас бусад нь цөм ер бусын тунгалаг харанхуйгаар хучигдсан мэт харагддаг.

Үүдэн хоймрын хэртэйгээс харахад

“Жоконда” хар хүрэн үстэй. Луврт байдаг жинхэнэ эх зургийг харахад

нүүр царай

нүүгэлтсэн энэ хар бараан өнгөн дундаас гэрэлтэн харагдаж байгаа

өөдөөс нэвт шувт ширтсэн ухаалаг харц, булбарай хүзүү, цээж, донжтой тавьсан хоёр гар нь энэ бүсгүйг

гэгээн гунигтай болгож байгаа юм.

.....






Алхам 3: Цэгийн оронд тохирох мэдрэмж сэтгэгдэл илэрхийлсэн үгсийг зөв сонгож, зэргэлдээ зураасанд харгалзуулж бичнэ үү.

Сонгох үг хэллэг: гэрэл тусаад, их, нийтлэн шарлав, тунгалагаар цэлмээд, дүгрэг том, мандан, урьхнаар, зөөлнөөр найгаад, хэсэг хэсгээр тунана, дэлгэрэнгүйеэ хангинаж, яруухнаар дуурсана, ариун, цээж дүүрэн, залгалдана, гилтгэнээд, нимгэн цагаан, үнэхээр тааламжтай.

1. хөхөө шувуундонгодох дуу _____
2. уулын цуурай ба салхины аятай хослон, өргөн талд _____
3. энэ үе сайхан зуны тэргүүн сарын шинэд тул дэлхийн бодис, цагийн улирал ... _____
4. хөх тэнгэр _____
5. хөвөн үүл _____

6. дэргэдэх ургамал цэцгэнд хяруу
7. тэртээ ой модонд ногооны униар
8. урьхан салхи
9. агаар амьсгалуулна.
10. Удалгүй нар гарч ирэхэд
11. Баруун ба хойд уулын орой ба энгэрээр, өмнөх талд туяа

Алхам 4: Зураг тус бүрд тохируулан, 5 аас доошгүй мэдрэмж сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэг олж бичнэ үү.

	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>

Дээрх мэдрэмж сэтгэгдэл илэрхийлсэн үгсээс 3 ыг сонгож өгүүлбэрт оруулж бичнэ үү. Үлгэрлэвэл:

Мэдрэмж илэрхийлсэн үг ба өгүүлбэр: тэнгэрт хуралдах үүл, тэртээд цайрах бороо, хөллөн ойртох бороо, хүндэт зочин айсуу мэт, хотод суудаг хүү нь сумын төв дээр ирээд гэртээ оролгүй буцчихсантай адил

Өгүүлбэрт оруулсан нь: Говийн малчин үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл хээрийн бэлчээрт мал дагахдаа тэнгэрт хуралдах үүл, тэртээд цайрах бороог нэгэн адил хариулж, хөллөн ойртох бороо харахул хүндэт зочин айсуу мэт баярлах бөгөөд хэрэв тэр зурвасхан бороо хажуугаар нь өнгөрвөл хотод суудаг хүү нь сумын төв дээр ирээд гэртээ оролгүй буцчихсантай адил гомдонхон бухимдана. (Ж.Л)

.....

Алхам 5. Өгсөн жишээ баримтад тулгуурлан сэтгэгдлээ илэрхийлнэ үү. Үлгэрлэвэл:

Жишээ баримт нь: Зохиолч Ч.Лодойдамбын тухай түүний шавь “*Манай багш физикийн хичээл зааж байхдаа самбар дээр юм зураад түүнийгээ гараараа баллаад түүгээрээ хувцас нүүрээ будаж цагаан эрээн болоод гардагсан. Тэр бусдад өөрийн хэлсэн зүйлийг ойлгуулах гэж ухаан бодлоо дайчилдаг багш байсан юм*” гэжээ.

Сэтгэгдэл нь

Үүнээс үзэхэд Ч.Лодойдамба гуай бусдын төлөө өөрийгөө мартдаг хүн байжээ.

Жишээ баримт	Баримтаас төрсөн миний сэтгэгдэл
<p>1. Г.Аюурзана” Мэдэхгүйн тухай яриа” хэмээх эсээндээ “Чулуу бол хэдэн мянган жилд нэг удаа амьсгалдаг амьд биет” гэсэн дүгнэлтийг саяхан хэсэг эрдэмтэд гаргасныг дурджээ.</p>	<p>..... </p>
<p>2. Миний хамгийн их ач холбогдол өгсөн, надтай тохиолдсон нэгэн өвгөний яриаг уншигчид нэг их анзаараагүй. Би тэр өвгөнийг 1992 оны зун Шаргалжуутад харсан юм. Торниухан ургаа хад бүхэнд чихээ наан удтал суудаг мөнөөх өвгөнтэй нэг удаа зориуд уулзаж, учрыг асуувал: Намайг багад энд нэг гозгор чулуу байсан юм. Зүрхний эмгэгт их сайн гэлцдэг байв. Түүнд чихээ наан чагнахад яг л хүний зүрх цохилж байгаа юм шиг, лүг лүг хийн цохилох сонсогддог байсан. Сүүлийн хэдэн жил би тэр л чулууг хайж явна. Ерөөсөө олж чадахгүй байна гэж билээ. (Г.Аюурзана” Мэдэхгүйн тухай яриа”)</p>	<p>..... </p>

Алхам 6. Зураг тус бүрийг холбоо үгээр нэрлээрэй. Холбоо үгсээ зурагт тохируулан холбож, уран дүрслэлийн аргаар мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлнэ үү.
Үлгэрлэвэл:



Сарны туяа

Мэлтэлзсэн сүү

Мэлтэлзсэн сүү шиг сарны туяа (Ж.Б.)

1.



.....

.....

2.



.....

.....

3.



.....

.....

Мэдрэмж сэтгэгдэл илэрхийлсэн үгсээ өгүүлбэрт оруулж бичээрэй.

.....

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ...он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Дасгал ажил 2. Үзэл бодлоо илэрхийлэх



Мэдлэг мэдээлэл, баримт нотолгоо + Өгүүлэгчийн сэтгэгдэл, дүгнэлт = Үзэл бодол

Сэтгэгдэл мэдрэмж нь тухайн агшны баярлах, гуниглах, айх, гайхах, уурлах гэх мэт сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй тул голдуу тухайн зүйлд хандаж буй өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аяс баймж утгаар илэрдэг бол **үзэл бодол нь** хувь хүний амьдралынхаа явцад уншиж судалсан, ойлгож ухаарсан, мэдэж тунгаасан, сонсож дуулсан, үзэж харсан гэх зэрэг үйлийн явцад төлөвшиж тогтсон санаа бодлын илэрхийлэл юм. Аливаа зүйлд туйлширдаггүй, олон ургальч үзэл бодлыг чухалчилна. Нэг зүйлийг дор хаяж хоёр талаас, цаашлаад олон талаас үзэж, судалж, тунгааж бодож байж үзэл бодлоо илэрхийлдэг.

Алхам 1. Өгүүлбэрүүдийг мэдрэмж сэтгэгдэл ба үзэл бодол илэрхийлсэн хоёр утгад өнгөөр ялгаж тэмдэглээрэй.

№		Мэдрэмж сэтгэгдэл	Үзэл бодол
1.	Би таны шүлгийг уншаад, үнэн бөгөөд гунигтай сэтгэгдэл төрлөө. (Д.Н)		
2	Монголын шинэ соёлыг хөгжүүлэх үйлсэд авьяас билгээ бүрэн зориулж зохиол бүтээлээрээ хувь нэмэр оруулсан суут хүмүүсийн нэг бол яахын аргагүй Дашдоржийн Нацагдорж юм. (Б.Т)		
3	Тэрээр байгаль нийгэм сэтгэхүйн үзэгдлийг танин мэдэхүйн үнэн зөв хандлагын үүднээс ухаарч түүнийгээ уран бүтээлдээ ул суурьтай илэрхийлдэг байжээ. (Б.Т)		
4	Юунд ч юм яараад байгаа юм шиг. (П.Б)		
5	Хурданд тийм тогтмол хязгаар үгүй санагдана. Нэг үгээр хурдлаад байвал хурдлаад л байна гэсэн үг. (Б.П)		
6	Бие нь өчүүхэн мөртлөө амьдрах аргаараа том энэ амьтан дэлхий дээрх 50 мянган төрөл зүйл аалзны нэг нь гэхдээ элсээр урхи, тор хийдгийн хувьд тэр олны дундаас онцгой юм. (Л.Т)		
7	Аалз аугаа их цэвэрлэгч, аугаа их махчин ажээ. Үлгэрт гардаг мангасын өвөг дүр юм болов уу? (Л.Т)		
8	Хүний зөгнөл зөвхөн эд хогшил, багаж хэрэгсэл, техник технологи болон хувирдаг төдийгүй зураг урлал, аялгуу хөгжим, уран зохиол болон хувирдаг. (Л.Т)		
9	Ижийтэй хорвоо л юутай жаргалтай. (До.Ц)		

10	Маргааш юу болохыг урьдчилан таамаглах, тэгэхдээ бүр шинжлэх ухааны аргаар онош тавих нь өнөөдрийн хувь заяатай шууд холбоотой тул нэгэнт өнгөрснөөрөө хий хоосон бардамнах биш угтан учирч болох ирээдүйн тухайд нухацтай бодлого барьж, дороо суурьтай дотроо бодолтой аж төрөх нь мэргэн ухаарлын шинж юм. (Л.Т)		
----	---	--	--

Алхам 2. Өгүүлэгч нь үзэл бодлоо илэрхийлсэн хэсгийг жишээ баримт, мэдрэмж сэтгэгдлээс ялгаж будаарай. **Үлгэрлэвэл:** Агаарын бохирдлоос болж сүүлийн үед өвчлөл нэмэгдэх болсныг ХСҮТ-ийн цээжний хөндийн мэс заслын тасгийн эрхлэгч Б.Ганзориг хэлэв. Хотын утаанд хорт бодисын хэмжээ ДЭМБ-ын зөвшөөрсөн хэмжээнээс 7-10 дахин өндөр байгаа нь эл өвчнийг үүсгэх гол шалтгаан болж буйг тэрбээр тодотгосон. Агаарын бохирдлыг бууруулахгүй, энэ байдлаараа үргэлжилбэл 20 жилийн дараа гэхэд монголчуудын олонх нь уушгины хавдартай болох магадлал өндөр байгаа аж. (“Өнөөдөр” сонин 2016. О.Бат - Ундрах)

1. ... Цасгүй шахам бас намар шиг налгар өвлийн сүүлчээр бид Ховд аймгийг зорив. Онгоцны цонхоор харахуйд Архангайн хойд, Завханы урд талын нутаг нэлдээ хар байсаар Дөргөн нуур хүрэхийн аяст оочин цоочин цастай нь нээрээ газар сайгүй өнтэйхөн өвөл болж буйн шинж ажээ. Төд удалгүй бадарч байгаа гал шиг хэдэн шовх улаан уулсын дунд орших зуун зууны түүхтэй Ховд хотод буулаа. Ховд нутгийн онцлог гэвэл говь, хангай хээр тал үргэлжлэх бүр тэгээд мөнх цаст уулс олонтой нь гайхамшиг гэж болно. Ховдчууд туйлын хөдөлмөрч түмэн. Малаа маллах өвөрмөц гэхээр өв уламжлалтай гэдэг. Жилийн жилд Буянт, Ховд голоо дагасан үржил шимт нутгаараа үр жимс, тариа будаа арвин тариалдаг. (“Зууны мэдээ” сонин. 2015. Д.Цэрэннадмид)
2. ... Хэний морьд түрүүлж өнгөлсөн, хэний хүү бэлтэй баяныг гайхан шагширч суух энэ хэдэн өдөрт 37 хүүхэд мориноос унаж бэртсэн тухай хэвлэлүүд мэдээлсэн байна. Сүхбаатар аймгийн аварга шалгаруулах дээд гурван насны морьдын уралдааны үеэр 24 хүүхэд мориноос унаж, хоёр хүүхдийнх нь тархи доргиж, цээж нь битүү гэмтсэн гэсэн оноштойгоор эмнэлэгт хэвтжээ. Унаач хүүхдүүдийн эрхийг хамгаалахаар сануулсаар, шаардсаар байтал өнөөдрийг хүртэл өвлийн хүйтэнд бүсийн уралдаан зохион байгуулагдсаар, хүүхдүүд эрүүл мэнд амь насаараа хохирсоор байна. Энэ цаг үед зам харгуй хөлдүү, цас мөс, шавар шавхайтай учраас хүүхэд мориноос унах эрсдэл өндөр бөгөөд хүйтний улирал учраас хүүхдүүд гар хөл, хацар, нүүрээ хөлдөөх явдал байнга гарч байна. (“Зууны мэдээ” сонин. 2015. Х.Монголхатан)
3. ... Чехийн Варшав хотод болж өндөрлөсөн Европ тивийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд манай жүдогийн баг тамирчид амжилттай оролцлоо. Нэг бөх аварга болж, хоёр бөх хүрэл медаль хүртсэн байна. Жүдо бөхийн шигшээ багийн тамирчин Азийн наадмын мөнгөн медальт ОУХМ Г.Одбаяр 73 кг-ын жинд Х.Цагаанбаатар, Г.Ням-Очир, С.Миярагчаа нарын хойчийг залгамжлан гарч ирж байгаа бөх. Энэ онд улсын аварга болсон амжилтын буухиагаа хилийн чанадад үргэлжлүүлж Европын аварга гэсэн эрхэм цол авч ирлээ. (“Зууны мэдээ” сонин. 2015. Д.Цэрэн)

Алхам 3. Үзэл бодлоо илэрхийлэхийн тулд аливаа зүйлийг олон талаас нь тунгаан бодож үндэслэлээ гаргана уу. Үлгэрлэвэл:



Хүмүүс яагаад өөр өөр шампунь хэрэглэдэг вэ? Үүнийг дараах байдлаар олон талаас тунгаан бодож үзэл бодлоо илэрхийлнэ. Таван шалтгаан дурдвал:

Бодисын дотоод бүтцийн үүднээс шампуний найрлага өөр өөр байдгаас

Хүн хүний үсний онцлог өөр өөр байдгаас

Хүн, хүний сонирхол өөр өөр байдгаас

Хүмүүсийн санхүүгийн чадавх ялгаатай байдгаас

Шампуний олдоц, хот хөдөөгийн ялгаанаас



Томоохон хот суурин газарт нийтийн тээвэр яагаад чухал вэ? Аль болох олон талаас тунгаан бодож, үндэслэлтэй таван өөр шалтгаан бичээрэй.

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....



Хүн яагаад журам дүрмийг сахиж амьдрах ёстой вэ? Аль болох олон талаас тунгаан бодож, үндэслэлтэй таван өөр шалтгаан бичээрэй.

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

Алхам 4. Баримт ба үзэл бодлын хэсгийг холбон нэг өгүүлбэр бүтээнэ үү. Бүтээхдээ утгын алдаагүй аль нэг үг, хэсгийг хасаж, танаж найруулж болно. **Үлгэрлэвэл:**



Япончуудын хувьд “Төвөг болчихлоо уучлаарай” гэдэг үг амны уншлага шиг болсон байдаг нь газар нутаг жижиг, хүн ам ихтэй гэхээсээ илүү бусдыг хүндлэх үзэл бодолтой нь холбоотой юм.



Баримт:

“Төвөг болчихлоо уучлаарай” гэдэг үг Японд амны уншлага гэлтэй хамгийн их сонсогддог үг хэллэг. Япончууд бусдад төвөг болохгүй амьдрахыг туйлын их хүсдэг ард түмэн юм.

Үзэл бодол: Энэ нь зөвхөн газар нутаг жижиг, хүн ам ихээс шалтгаалдаггүй байх. Нөгөө л бусдыг хүндлэх, хүний орон зайд нэвтэрч болохгүй гэсэн үзэл бодолтой нь холбож болмоор юм.

Баримт	Холбон найруулсан нь	Үзэл бодол
Манай улсын 2015 оны эрүүл мэндийн яамны статистик мэдээнээс үзвэл, халдварт бус өвчлөлийн дотор бөөрний өвчнөөс болж нас барсан тохиолдол жил ирэх бүр өсөж байна. Үүнд, хөдөлмөрийн ид нас буюу 20-45 хүртэлх насны хүмүүс илүү их өвчилж байгааг тогтоожээ. (“Монголын мэдээ” сонин 2016)	Эдгээр хүмүүс ихэвчлэн хүүхэд байхдаа бөөр нь үрэвсэж, тэр нь яваандаа хүндэрсэн байдаг тул хүүхэд байхаасаа бөөрөө хамгаалж байх хэрэгтэй юм.
Хакухо сэтгүүлчидтэй уулзахдаа “Миний аав улсын наадамд зургаа түрүүлсэн. Наадам жилдээ ганц удаа болдог болохоор сумогоор бол 36 удаа башёд түрүүлсэн гэсэн үг. Тэгэхээр би аавынхаа тэр түрүүтэй зэрэгцэхийн төлөө хичээнэ” гэжээ. (“Монголын мэдээ” сонин 2016)	Энэ үг бас Япончуудыг айлгасан байх. Гэхдээ Хакухо түрүүлэх магадлал өндөр байгаа. Энэ оны эхний хэдэн башёд л лав түүнийг зогсоох хүчтэн байхгүй гэж бодож байна.
“Галыг тахилга” – д “Чин чулаан эхт, Чингил төмөр эцэгт...” хэмээн өгүүлдэг.	“Чин” гэдэг нь чулууны машид хатуу чанарыг илтгэж, үнэнхүү хатуу гэсэн утгаар явж байна.
Шунал хэмээгч хамаг зовлонгийн үр үндэс болдог тухай Бурхан багш сургажээ.	Өнөөдөр Монголчууд авах идэх шуналаараа өрсөлддөг, түүгээр гоёдог болчихоо юу гэлтэй мөнгө олзонд улайрдаг болоо юу даа.
Өнгөрсөн оны сүүлийн хагас жилд 1800 хүүхэд түлэгдэн тус төвд хүргэгдэж арьс нөхөх эмчилгээ хийлгэжээ. Ялангуяа халуун тогоотой хоол, буцалсан ус зэрэгт түлэгдсэн хүүхэд олон байгаа аж. (“Өнөөдөр” сонин 2016.03 сар)	Эцэг, эхчүүдийн анхаарал хайхрамжгүй, хариуцлагагүй байдлаас болж бага насны хүүхэд түлэгдэх тохиолдол цөөрөхгүй байна.

Алхам 5. Дараах баримт мэдээллийг өөрийн үзэл бодлоор дэлгэрүүлж бичээрэй.



Баримт жишээ: Цаст бүрэн дунд сургуулиар орлоо. Тус сургууль 1200 гаруй сурагч, 70 гаруй багштай. Сургууль хамт олны эрхэм зорилго нь: Бүх үйл ажиллагааг хүүхэд бүрд буюу нэгжид тулгуурлаж, сурагч, эцэг эхчүүдийн санал бодлыг сонсож ажилладагт оршдог юм байна. “Оюуны наадам” – ыг сүүлийн гурван жилд олон төрлөөр зохиожээ. Түүний нэг нь рубик шоогоор наадах. Хүүхдийн ой ухаан, авхаалж самбааг хөгжүүлэхэд энэ тоглоомыг чухал хэмээн сонгожээ. Сургуулийн хэмжээнд 800 – аад хүүхэд энэ шоог эвлүүлж сурчээ. Гоц хүүхдүүд ч байна. Эхэн үед 50 гаруй секундэд эвлүүлдэг байсан бол одоо 23 секундийн амжилт олон хүүхэд үзүүлжээ.

Үзэл бодлоо илэрхийлж бичихдээ аль болох олон талаас бодож, дараах холбоос хэрэглүүрээс сонгож ашиглаарай.

- Миний туршлагаар...
- Миний үзэж байгаагаар...
- Миний бодоход...
- Онцолж хэлэхэд...
- Юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр...
- Миний хувьд ... гэдэг нь
- Би ... гэж л бодоод байна.
- Миний ойлгосноор...
- Ер нь ... гэж болох юм.
- Баримтаас харахад... гэж болохоор байна.
- Мэдээжийн...
- Миний олж мэдсэнээр...
- Би... гэж үзэж байна.
- Би ... гэж бодож байна.
- Ер нь ...
- Үнэн хэрэгтээ
- Чухамдаа ...



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн овог нэр: Эхэлсэн он ... сар... өдөр ... цаг
 Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг



Дасгал ажил 1. Таамаглал дэвшүүлж бичээрэй.

Таамаглал дэвшүүлэн тайлбарлах: Ямар нэг асуудлын талаар тодорхой шинжилгээ, судалгааны үндсэн дээр учир зүйтэй таамаглал гаргаж тайлбарлахыг хэлнэ. Таамаглал нь ихэвчлэн үнэн юм уу, худал гэсэн хоёр хариун дээр тогтдог. Тиймээс таамаглаж тайлбарлах нь ямар нэг ажиглалт, судалгаа, баримт нотолгоо, эрэл хайгуул хийхийг шаарддаг. Тэгэхлээр ул суурьтай ажиглалт, судалгаанд тулгуурлан таамагладаг гэсэн үг.

Алхам 1. Цэгийн оронд таамаглах баймж утгат үгсийг тохируулан нөхөөрэй.

бололтой, байж болох юм даа, магад буюу, болзошгүй байдаг, бололтой, байдаг болов уу?, байгаа хэрэг бололтой, мэддэг байж таарна, болзошгүй, магадгүй байна, байж болох юм

1. Эхийнхээ дууг сонссон Бат гвйн очив. Ганц хүүгийнхээ толгойг элгэндээ тэврэн аваад енгэнэтэл уйлж байхдаа хорвоо дээр зовлон байвч жаргал бас байдгийг бүх сэтгэлээр мэдэрч байлаа. «Амьд явбал алтан аяганаас ус ууна» гэж Дэжид гуайн давтан ярьдаг нь энэ уулзалтыг л хэлсэн (Ч.Л)
2. Эрдэнийн сэтгэлд Долгор бодогдов. Амьд мэнд явбал хэзээ нэгэн цагт түүнтэй уулзах мэт санагдав. Би дэндүү ширүүн зан гаргасан болов уу? Тэр минь намайг дагаж зовлон үзсэн хүн дээ. Хатуу амьдрал үнэнч сэтгэлийг нь сохолсон ч (Ч.Л)
3. Га гүн хоёр жилийн өмнөхийг бодвол бие нь сайжирч сэргэлэн шаламгай болсон нь засаг төрийн хэрэгт сэтгэл өөдрөг (С.У)
4. Эцэг өвгөд минь амиа дүйж хамгаалсан энэ газар шороог бид хойч үе алдвал амьд явахын хэрэг юу вэ? Харийн түрэмгий этгээдийн хөлд харц ядуу ард улам доройтож үндсээрээ мөхөж сөнөхөд хүргэхгүй арга (С.У)
5. Коронавирусын тохиолдол эрс нэмэгдэж, ган гачиг нүүрлэсэн нь Энэтхэгийн цайны тариалан эрхлэгчдэд ургацаа хураахад саад учруулж байгаа бөгөөд хэрэв халдварын дэгдэлтийг хяналтдаа авч чадахгүй бол цайны үнэ нэмэгдэж (соиноос)
6. Аливаа цэвэрлэгээг хийсний дараа тоног төхөөрөмжөөс тухайн цэвэрлэгээний бодисыг бүрэн арилгаагүй тохиолдолд үйл ажиллагаанд ашигладаг бусад химийн бодистой урвалд орж (соиноос)
7. Хэрвээ таны хэрэгтэй бүхэн чинь хаана байгаа нь тов тодорхой байдаг бол, хийж амжуулах ажил чинь бас л тодорхой болно. Ажлаа хэзээ дуусаж, хэзээ амрахаа мэдэж байгаа хүн. Яг ямар үед завтай байх аа ч Үргэлж завгүй байдаг хүн цаг ямагт эмх замбараагүй байдалдаа түүртдэг (соиноос)
8. Тэгээд мөнх билгийн лянхуа цэцэг сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж (Б.Р)

Алхам 2. Таамаглал дэвшүүлсэн эхийг дэлгэрүүлэн, нөхөж бичээрэй. Дараах дарааллыг эргэн санаарай.

Ажиглалт – Асуулт – Таамаглал – Санал – Нотолгоо – Дүгнэлт

... Соёлын гавьяат зүтгэлтэн, авьяас билигт яруу найрагч Дан. Нямаагийн “Хомоол” бичил таталбарт “... Хомоол, адуун зүсээ дуурайж хувирна. Хатаж байгаа хомоолд хар зүс голлоно. Аажмаар нарны шим, салхины бидэрт хуурайшсаар “хар халтар” болно. Хялгана сүвлэсэн талд сарны туяа, одны гэгээг шингээсээр борлог болно. Тэр өнгө нь хувиран хувирсаар тэнгэрийн өнгөнд уусаж, хөв хөх болно. Хөх хомоол шидтэй. Элдэв өвчнийг анагаадаг хэмээн хэлэлцэнэ. Түүний цагаан үнсийг хярам, сүү, хар шөлөнд найруулж ууна. Хууч өвчнийг эдгээнэ. Хөх хомоол хайсаар их хол явна. Аглаг тал, уулын хяр, ургамлын соргогтой хөдөө хээрээс л эрнэ шүү дээ. “Нарийний гол” – доо уралдуулах “хурдан ажнай” хайж яваад холбоотой хомоол олоод, ихэд баярлана. Түүнийгээ “дааган холбоо” гэх бөгөөд “хос морьтой” хүн болж нөхдөдөө гайхуулан, гэгээн алсад одохын зөнд автдаг сан...” гэсэн нь юм болгонд бэлгэ дэмбэрэл боддог босоо бичигтэй монгол хүний гэгээн ухааны илэрхийлэл болж байна...

Ажиглалт



Асуулт

Монгол хэлнээ “хом” хэмээх нэг язгуурт үгийн үүр байна. Эдгээр үгийн язгуур “хавчих”, “дарах”, “нухах” гэсэн утгатай байж болох. Энэ үгс нь монгол хэлний “хомоол” хийгээд “хомбого”, “хомбогор”, “хомбон”, “хомбойх” гэх мэт үгстэй бүтэц утгын холбоотой байж магад юм.

Таамаглал

Санал

Толь бичгийн толгой үгсийн жагсаалт энэ тэрийг сонирхоход, тэмээний “хом” буюу тэмээнд нуруу ачаа ачихад зоо нурууг нь хамгаалж бамбайлан нөмөргөдөг эсгий хөлсөвч – “хом”, бас тэргэнд хөллөх малын хүзүүнд өмсгөн, оосроор тэрэгний аралд холбодог “хом” буюу “хомут”, мөн тэрчлэн тарган тэмээний хоёр бөхний хажуу зураг дагаж гардаг хэсэг талбайн бөөн өөх буюу “хом” өөх зэрэг нь “хом” гэсэн нэг язгуурт үгсийн үүрийг үүсгэдэг байна.

Нотолгоо

Тэгэхлээр “хом”, “хомут”, “хомоол” гуравт утгын ба хэлбэрийн холбоо хэлхээ байгаа бөгөөд дүрс дуурайж үүссэн үгс гэж үзэх үндэстэй байна.

(Б.Пүрэв - Очир)

Дүгнэлт

Алхам 3. Таамаглах баймж үгсээс сонгон ашиглаж өгүүлбэр зохионо уу. Уран зохиолын хичээлтэйгээ холбоорой.

Баймж үгс нь: *Бололтой, магадгүй, байж магад, байж мэднэ, боломжтой, бололцоотой, юм биш байгаа, янзтай, шинжтэй, янз нь, миний бодлоор, энэ янзаар бол, царай нь, ... царайтай, байдалтай, төлөвтэй, болов уу, юм болов уу, байж болох юм, байх, маягтай, мэдэшгүй, гэж үзэж болох юм, байж болно, болов уу хэмээн санана, тэр байх, тийм байдаг байх, ёстой болов уу?, тэр биз, биз... , тийм ч юм шиг, байж ч болзошгүй г.м.*

Үлгэрлэвэл:

“Чингисийн эр хоёр загалын тууж” зохиолын их загалаар

“Чингисийн эр хоёр загалын тууж” зохиолын их загалаар эх нутаг, элгэн түмэн, ээж ааваа гэсэн сэтгэлийг илэрхийлсэн **бололтой**.



Яруу найрагч
Б.Явуухулан
“Бууж үдлэм холоос
Айл нь харагдах хачин
Бугуйл хаям ойроос
Нар нь мандах сонин”
хэмээн шүлэглэсэн нь

.....
.....
.....
.....



Сөнидийн Гилэгүдэй баатар
“Халих харцагайн жигүүр
болон одов уу чи, эзэн минь!
Хангинах тэрэгний тээш
болон одов уу чи, эзэн
минь!” хэмээн шүлэглэсэн
нь

.....
.....
.....
.....
.....



Мандухай цэцэн хатны
домогт
“Долоон нуган
заяаваас долууланд
Болд нэр өгч,гал
голомтыг чинь
сахиулъя” хэмээн
өгүүлсэн нь

.....
.....
.....
.....



Цогт тайжийн хадны
бичигт
“Хол ойроос хулгай
хийгч хүмүүн
хийгээд
Хотыг эргэн гэтэгч
чоно хоёрын
Илт бие дүр өөр
болбоос
Идэхүйг хүсэх
сэтгэлийн агаар
нэгэн буй” хэмээн
шүлэглэсэн нь

.....



Б.Ринчений “Нууцыг задруулсан захиа” туурьд, ээж нь Шуну хүүдээ: “Үрийн сэтгэлээр төрүүлж өсгөсний минь ачийг санаж мэдэж яваа бол үхэхийнхээ өмнө эцэг эхийнхээ захисан сургаалыг дагах нь ёстой дээд элбэрэл гэгч тэр шүү. За хүү минь зориг хатамжил.” хэмээн өгүүлсэн нь

.....
.....
.....
.....

Алхам 4. Асуултад хариулахдаа, олон талаас тунгаан бодсон үндэслэлтэй таамаглал дэвшүүлж бичнэ үү.

	Асуулт	Үндэслэлтэй таамаглал дэвшүүлж хариулна уу.
	Бусадтай харилцахдаа, яагаад тэдний санал бодлыг сайтар сонсож үзэл бодлыг хүндэтгэх ёстой вэ?
	Яагаад дүр төрх, зан чанар, өссөн орчин өөр гэдгээ хүлээн зөвшөөрч, бие биенээ ойлгож эвтэй нөхөрлөх ёстой вэ?
	Яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй дотно харьцаж, тусламж хэрэгтэй үед нь хичээнгүйлэн туслах ёстой вэ?
	Яагаад олон нийтийн газар бусдад садаа болохгүй соёлтой байж, биеэ зөв авч явах ёстой вэ?
	Хүн эрүүл цэвэр орчинд амьдрах эрхтэй. Тэрхүү цэвэр орчноо өөрөө бүрдүүлэх үүрэгтэй байдгийн учир юу вэ?
	Хүүхэд яагаад зурагт үзэж, интернэт ашиглахдаа насандаа тохирсон сайн мэдээлэл авах ёстой вэ?
	Бусдыг яагаад хочоор нь биш, нэрээр нь дуудах ёстой вэ?
<p>Аль нэг хэсгийг сонгон, таамаглалаа баталж нотолж дүгнэлт гаргана уу.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>		

Алхам 5. А, Б эхээс таамаглал дэвшүүлэх боломжтой асуух өгүүлбэр 10 – аас доошгүйг гаргаж бичээрэй. Хариултыг багш болон ахмад хүмүүсээс асууж, уншиж судалж олоод ярилцаарай. Үлгэрлэвэл: **Морио арилжихдаа ногттой нь өгч болдоггүйн учир юу юм бол? Эхийг “Ийм нэгэн гуниг ... Ийм нэгэн ... Ийм.” хэмээн төгсгөсний учир юу юм бол? гэх мэт.**

А. Арилжаа

Морио хүнд арилжихдаа ногттой нь өгч бай гэж хэн сургасан юм. Монголоо алдмарууд гэж айлын буурал бухимдсаар гэрийн зүг түргэн түргэн алхав. Залуус морины арилжаагаа хонжоотой хийсэн бололтой хөхрөлдсөөр ирж гэрийн сүүдэрт тухалцгаав. Зэргэлдээ сумын уяач галигуулсаар зэрэглээ сүвлэн одлоо. Буурлын үг дахин дахин бодогдоно. Тэр морьтны бараа харагдахгүй болсон ч тэр морьтныг дагаад нэг сайхан зүйл минь явчихсан ч юм шиг өдөржингөө сэтгэл хоосров. (Ц.Бавуудорж)

1.
- . .
2.
- . .
3.
- . .
4.
- . .
5.
- . .
6.
- . .
7.
- . .
8.
- . .
9.
- . .
10.

Б. Зөв, сайхан

Эмээл дээр зөв сууж сур... өвөө ийн хэллээ. Ийм сайхан эмээл дээр сайхан суувал жигтэйхэн сайхан харагдана даа. Айлын буурал бас ийн нэмэв. Зөв суух... сайхан суух ... Хориод жилийн тэртээ нутагтаа очих үеэр хоёр сайхан буурал ийн хэлсэнсэн. Олон сайхан үйл явдал, олон учрал тохиол мартагдаж одсон ч гэрийн баруунтаа шондсон хуучин эмээлээ харах бүрт энэ үг сэртхийнэ. Зөв, сайхан хоёр нэгэн насны чимэг аж. Би өөрийгөө чимж чадсан. Амьдралаа чимж чадсан. Гэвч надад нэгээхэн гуниглал бий. Зөв, сайхан хоёрын утгыг зөрүүд хэдэн дүү нартаа учирлаж чадаагүйн гуниг. Ийм нэгэн гуниг ... Ийм нэгэн ... Ийм. (Ц.Бавуудорж)

1.
- . .
2.
- . .
3.
- . .

4.
5.
6.
7.
8.
9.
10.

Алхам 6. “Цагаан сар” – ыг яагаад ийнхүү тодорхойлсныг эргэцүүлэн бодоод таамаглал дэвшүүлсэн өгүүлбэр болгож хувиргана уу.

Үлгэрлэвэл: “Цагаан сар бол хүмүүний ээнэгшилт ёс” гэснийг *“Монголчууд, цагаан сараараа ах дүү, айл хотлоор, амар жимэр, аятай сайхан баярлаж хар бүхнийг умартан, цагаан сэтгэлээр уулзан золгоцгоодог тул “хүмүүний ээнэгшилт ёс” хэмээн тодорхойлсон болов уу.*

- ЦАГААН САР БОЛ хүмүүний ээнэгшилт ёс.
.....
- ЦАГААН САР БОЛ монгол эрхэмсэг намба.
.....
- ЦАГААН САР БОЛ ах зах, өтгөс нялхсын нандин дэг.
.....
- ЦАГААН САР БОЛ төр сүлд, уул устайгаа харьцахын их соёл.
.....
- ЦАГААН САР БОЛ дорнын буурал дадал заншлын хэмжээлшгүй өв.
.....
- ЦАГААН САР БОЛ харыг тэвчиж, цагааныг үйлдэхийн сургамжит бэлгэ дэмбэрэл.
.....
- ЦАГААН САР БОЛ цугаарыг товчоолж багтаасан шинэ оны магнай тэргүүн өдрийн агуу их баяр.
.....
- ЦАГААН САР БОЛ лавтайяа, гурван мянга таван зуун жилийн хуртай Монголын их зан үйл мөн.
.....

Алхам 7. А. Эхийн үйл явдлыг таамаглаж, орхисон хэсэгт тохируулан 1 – 3 хүртэл өгүүлбэр нөхөж бичээрэй. Эх нь гол санаатай байх ёстойг анхаарна уу.

Өрөөсөн гутал

Нэг хүн захаас үхэр худалдаж аваад гэрлүүгээ явжээ. Нэлээд явж байтал өмнө нь нэг өрөөсөн гутал хэвтэж байна гэнэ. Үзвэл, шинэвтэр гутал байна.

Уулын хормойгоор тойрч явтал бас нэг гутал хэвтэж байхыг сонирхон үзвээс түрүүчийн гутлын өрөөсөн нь байна. гэж бодоод,.....

Б. Түшмэл хааныг хэрхэн давсан болохыг таамаглан харилцан яриаг гүйцээж бичнэ үү.

Хэн нь хоолны сав бэ?

Хаан түшмэл хоёр чанасан мах идэж суухдаа түшмэлийн эс анзаарахыг далимдуулан, мөлжсөн ясаа хаан түшмэлийн өмнө тавиад байв.

- Чи ёстой хоолны сав юм. Урдах овоолоостой ясаа хараач! гэж хоолоо идэж дуусаад хаан хэлжээ.
- Түшмэл:

Учир шалтгааныг тайлбарласан эхийг задлан шинжлэх

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр




Учир шалтгааныг тайлбарласан эх гэдэг нь: Учир зүйн холбоотой асуудлыг олон талаас эргэцүүлэн тунгаан бодож, үндэслэлтэй баримт нотолгоонд тулгуурлан ЯАГААД? ЮУНЫ УЧИР? гэх мэт асуултад хариу болгож шалтгаан – үрийн холбоог тайлбарлан бичсэн эх юм.

Олон улсын судалгааны “MJ & RS” байгууллага, улс үндэстний газар зүйн байршлаас үүдэлтэй уламжлал, зан заншил, сэтгэхүйн онцлогийн өвөрмөц шинжийг эдийн засагтай нь харьцуулсан сонирхолтой судалгааг хийжээ. Арвич хямгачаараа дэлхийд зартай, сарвууныхаа завсраар савангийн хөөс ч илүү дусаадаггүй гэгддэг герман үндэстэн хөрөнгө оруулалтаа хуваарилж, хэрэгтэй газар нь шаардлагатай зүйлийг өгч чаддаг хамгийн сайн эдийн засагч – менежер улс болохоо харуулжээ. Учир нь орлого нь нийгмийн давхаргаас шалтгаалан харилцан адилгүй байдаг герман өрхүүдийг энэ судалгаанд хамруулахад бүгд санхүүгийн төлөвлөлтөө сайн хийж түүнийгээ ягштал мөрддөг болох нь харагдсан гэнэ. Ийм болохоор тэдний амьдралд санхүүгийн эрсдэл бараг гардаггүй. Манайхан шиг гэнэтийн асуудалд орж толгойгоо өвтгөдөггүй сайн талтай. Германчууд аливаа нэгэн бизнес эрхлэхээсээ өмнө тухайн зах зээлийн нөхцөл байдал, хүлээж болох эрсдэл, олж болох ашиг зэргийг харьцуулан өнөөгийн бодит байдлыг гаргаж ирээдүйн төлвийг нь бодитоор дүгнэж чаддаг болохоор санхүүгийн эрсдэлтэй хэзээ ч учирдаггүй ажээ. (Ж.Мөнх)

Дасгал 1. Учир шалтгааныг тайлбарласан эхийг задлан шинжилье.

Алхам 1. Эхийн гол санааг тодорхойлъя. Эхээс сонгосон дараах гурван үг хэллэгийн аль нь эхийн гол санааг илэрхийлж байна вэ? Тодруулж будаарай.



Алхам 2. Судалгааны үр дүнг илэрхийлсэн дүгнэлт өгүүлбэрийг сонгож дугуйлна уу.

А. Уламжлал, зан заншил, сэтгэхүйн онцлогийн өвөрмөц шинжийг эдийн засагтай нь харьцуулсан сонирхолтой судалгааг хийжээ.

Б. Герман үндэстэн хөрөнгө оруулалтаа хуваарилж, хэрэгтэй газар нь шаардлагатай зүйлийг өгч чаддаг хамгийн сайн эдийн засагч – менежер улс болохоо харуулжээ.

В. Ийм болохоор тэдний амьдралд санхүүгийн эрсдэл бараг гардаггүй.

Алхам 3. Алхам 1 ба Алхам 2 – т гүйцэтгэсэн даалгавраас үүдэж дараах өгүүлбэрийн цэгийн оронд гүйцээж дүгнэлт бичнэ үү.

Судалгаанаас гарсан дүгнэлт нь:.....

..... гэсэн өгүүлбэрээр илэрсэн бөгөөд, энэ нь “Алхам 1” – ийн тай тохирч байна. Иймээс энэхүү эхэд судалгааны дүгнэлт нь г илэрхийлжээ.

Алхам 4. Гол санааг илэрхийлсэн хэсгийг эх дээр тодруулж зураарай.

Алхам 5. Эхэд шалтгаан ба үрийн холбоог хэрхэн илэрхийлснийг задлан тайлбарлая.

А. Эхэд шалтгааны утгат гурван холбох үг байгааг олж бичээрэй.

Б. Тэдгээр холбоос үгийг ашиглан шалтгаан үрийн гинжин хэлхээг хэрхэн тайлбарласныг ажиглая. Эхээс шалтгаан үрийн холбоотой дөрвөн өгүүлбэрийг ялгаж бичээрэй. (Заавал эх доторх дарааллыг баримтлах албагүй. Шалтгаан үрийн утгын дарааллыг гаргаж бичнэ.)

Шалтгаан ↓
Үр ↓
Шалтгаан ↓
Үр

Алхам 6. Дээрх эхээс үүдэн өгсөн дараах гол санааны дагуу шалтгаан үрийн гинжин хэлхээг хэрхэн гаргаж болох талаар эргэцүүлж бодоод, эхийн төлөвлөгөө зохиож үзээрэй.

Шалтгаан		Үр		Шалтгаан		Үр
						Байгаль ээжийг хэдий чинээ хайрлаж хамгаалж, зөв хэрэглэнэ. Төдий чинээ буян болно.

Дууссан:онсарөдөр

Шалтгааны утгат холбох үг, нөхцөлийг таних, хэрэглэх

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Шалтгааны утгат өгүүлбэр нь дараагийн үйл явдал болох эх үндэс болж “ямар учраас?, яаж?, яахлаар?, яаснаас?, яасанд?, яагаад?, яавал? юу гэж?, яах гэж?” гэх зэрэг асуултад хариулагдана.

Дасгал 2. Шалтгааны утгат холбох үг, нөхцөлийг зөв хэрэглэе.

Алхам 1. Цэгийн оронд шалтгааны утгат холбох үгийг оновчтой сонгож бичээрэй.

Сонгож бичих холбох үгс: тул, ... аас, ... ны улмаас, учир, тиймээс, учраас,... ээс болж, улмаас

1. Хүний үйлдэл бүр ямар нэг үр дагаврыг тарьж байдаг үйл гарцаагүй гэдгийг ухаарч аливаа шунал, муу бүхнийг эрүүл ухаанаар ялах хэрэгтэй.
2. Хүн хангалуун байх гэсэн сэтгэл шунал, уур уцаартай, сэтгэл хангалуун биш атаархуу, муу санаатайн мунхаг харанхуй болдог байна.
3. Түлшгүй гал гэж үгүй. амар амгалангийн болоод аз жаргалгүйн шалтгааны аль аль нь чамд, өөрт чинь бий.
4. Өнөө үед шинжлэх ухааныг үл тоон хэтэрхий механик хөгжилд тэмүүлсэн ихээхэн хүчирхэгжсэн ч ёс суртахууны доройтолд орж, дур зоргоороо авирласныхаа горьг амсаж хүн ямар их эвдэрснийг цар тахал ухаарууллаа.
5. Тамхи татсаны уушгины хорт хавдар тусах үр дагавартай.

Алхам 2. Зүйр цэцэн үгсийг шалтгааны утгат холбоос ашиглан хувиргаж бичнэ үү. Үүний тул эхлээд, хувиргах үгийг оновчтой сонгон зурж тэмдэглэнэ үү. **Үлгэрлэвэл:**

Өлсөхөөрөө уурлуузай, өвдөхөөрөө уйлуузай.

Өлслөө гэж уурлуузай, өвдлөө гэж уйлуузай гэх мэт.

Эртний мэргэн сургаал

- Барс цагт босохгүй бол
Өдрийн ажил алдана.
Багадаа эрдэм сурахгүй бол
Насны ажил алдана.

Шалтгаант нийлмэл өгүүлбэр болгон хувиргасан нь

.....
.....
.....
.....

Эртний мэргэн сургаал

Хэнд эрдэм буй бол түүнд тус буй.
Хэнд эе буй бол түүнд нөхөр буй.
Хэнд эд буй бөгөөс түүнд харам буй.
Хэнд эрх буй бөгөөс түүнд хилэнц буй.

Шалтгаант нийлмэл өгүүлбэр болгон хувиргасан нь

.....
.....
.....
.....

Алхам 3. Өгүүлбэрээс шалтгааны утгат холбох үг, нөхцөлөөр солин найруулах үгийг олж доогуур зураарай. Түүнээс б – аас доошгүй хувилбар өгүүлбэр үүсгэж бичнэ үү. А хувилбарыг бүтэн өгүүлбэрээр бичнэ. Бусад хувилбарын зөвхөн солин найруулсан үгийг бичнэ.

Үлгэрлэвэл: Хэсэг хүүхэд нутаг буцсанаас хойш сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав. (П.Лувсанцэрэн)

- а. Хэсэг хүүхэд нутаг **буцсан учир** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.
- б. Хэсэг хүүхэд нутаг **буцсан тул** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.
- в. Хэсэг хүүхэд нутаг **буцсан учраас** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.
- г. Хэсэг хүүхэд нутаг **буцсанаас болж** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.
- д. Хэсэг хүүхэд нутаг **буцсанаас шалтгаалж** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.
- е. Хэсэг хүүхэд нутаг **буцсаны улмаас** сургуулийн байр байдал, бүх юм огт өөр болоод явчлав.

1. Өвлийн шөнө жихүүн, үүрийн жавар хайруу гэвч ээлжиндээ зөрчил гараагүй болохоор сэргийлэгчийн сэтгэл их л өөг, даарахыг юман чинээнд үл бодно. (Ж.Лхагва)

- а.....
-
-
-
-
- б.....
- в.....
- г.....
- д.....
- е.....

2. Бороо арилангуут өрх татах мэт наран гийгүүлж, хүүхдүүд зэлэн дээр татсан гайхамшигт солонгыг хөөсөөр сахаалт шахуу явчихад сайх солонго мөн л зэлэн дээрээ гайхуулан гоёмсоглосоор үлдэнэ. (Ж.Лхагва)

- а.....
-
-
-
-
- б.....
- в.....
- г.....
- д.....
- е.....

3. Шинээр учран золгох зуун бол бүх төрлийн юмын хурдац асар их нэмэгдэх зуун, дууны хурдыг хэд нугалан түрүүлж, гэрлийн хурдыг ардаа хийгээд сэтгэлийн хурдыг давж гарах зуун юм.

- а.....
-
-
-
- б.....
- в.....
- г.....
- д.....
- е.....

4. Миний өмнөх хоёр даага бие биеийнхээ өмнө гарах гэж хоорондоо тэмцэлдсээр байгаад хүч нь суларч аяндаа саарлаас минь хоцрох нь тэр. (Ж.Лхагва)

- а.....
-
-
-
- б.....
- в.....
- г.....
- д.....
- е.....

5. Мянга түмэн жил ертөнцийн тоосыг угааж, хүний амьдрал цогцолсон газар шорооны шимийг урсгалдаа шингээж, тэр тухай хожмын нэг өдөр шивнэн хэлэх хэлтэйсэн бол Онон мөрөн юуг эс хэлэх билээ. (С.Эрдэнэ)

- а.....
-
-
-
- б.....
- в.....
- г.....
- д.....
- е.....

Дууссан:онсарөдөр

Шалтгаант нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 3. Шалтгаант нийлмэл өгүүлбэрийг бичье. Өгсөн загварын дагуу шалтгаан үрийн холбоо бүхий өгүүлбэр зохиож бичээрэй.

Үлгэрлэвэл:

Хайр энэрэл хүлээцтэй тайван байдлыг сэтгэлдээ буй болгосон

Ашиглах холбоос: - аас⁴, - аар⁴, - вал⁴, - улмаас, - хлаар⁴, - ээс болж, учир, учраас, - х, -д, - тул, - улмаас, - ын харгайгаар, - үрээр, - ачаар, - тусаар, - уршгаар, - ийм болохлоор, - санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь: Хайр энэрэл хүлээцтэй тайван байдлыг сэтгэлдээ буй **болгосны учир буруу сэтгэлийн үйлдэл, муу хэв шинжээс ангижирчээ.**

1. Эрдэм мэдлэгийг бус эд хөрөнгийг шүт

Ашиглах холбоос: - аас⁴, - вал⁴, - улмаас, - хлаар⁴, - ээс болж, учир, учраас, - х, -д, - тул, - улмаас, - ын харгайгаар, - үрээр, - ачаар, - тусаар, - уршгаар, - ийм болохлоор, - санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь:

.....
.....
.....

2. Хүн буруу бодлуудаа хянаагүй

Ашиглах холбоос: - аас⁴, - вал⁴, - улмаас, - хлаар⁴, - ээс болж, учир, учраас, - х, -д, - тул, - улмаас, - ын харгайгаар, - үрээр, - ачаар, - тусаар, - уршгаар, - ийм болохлоор, - санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь:

.....
.....
.....

3. Хүн өөрөө аз жаргалыг хүсдэг шигээ бусдад аз жаргалыг хүсдэг

Ашиглах холбоос: - аас⁴,
- вал⁴, - улмаас, - хлаар⁴,
- ээс болж, учир, учраас, -
х, -д, - тул, - улмаас, - ын
харгайгаар, - үрээр, -
ачаар, - тусаар, -уршгаар,
- ийм болохлоор, -
санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь:

.....
.....
.....

4. Хүний буруу сэтгэлийн нөлөөгөөр гэгээн тунгалаг сэтгэл нуугддаг

Ашиглах холбоос: - аас⁴,
- вал⁴, - улмаас, - хлаар⁴,
- ээс болж, учир, учраас, -
х, -д, - тул, - улмаас, - ын
харгайгаар, - үрээр, -
ачаар, - тусаар, -уршгаар,
- ийм болохлоор, -
санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь:

.....
.....
.....

5. Бусад хүний бодол санааг үгүйсгэж хэтэрхий бардам дээрэнгүй явсан

Ашиглах холбоос: - аас⁴,
- вал⁴, - улмаас, - хлаар⁴,
- ээс болж, учир, учраас, -
х, -д, - тул, - улмаас, - ын
харгайгаар, - үрээр, -
ачаар, - тусаар, -уршгаар,
- ийм болохлоор, -
санаас⁴, -

Дэлгэрүүлэн зохиосон нь:

.....
.....
.....
.....

Дууссан:онсарөдөр

Шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 4. Эхийг хувирган бичье.

Алхам 1. Дараах эхийн утга санааг ойлгож, дүгнэн шалтгаан үрийн холбоо бүхий таван өгүүлбэр гаргаж бичнэ үү. **Үлгэрлэвэл:** Аюулаас сэрэмжлэхийн учир монголчууд хайр нь дотроо, хал нь гаднаа хэмээн хэлэлцдэг болсон байж магадгүй. гэх мэт.

Хайр харуусал

- Ээж минь та намайг яагаад сохолчихсон юм бэ дээ?
- Юм хийж байхад шөвөг авна гэж уйлаад болохгүй болохоор нь л өгчихсөн юм даа, хүү минь.
- Өгөхгүй л байхгүй дээ, ээж минь. Би уйлаад уйлаад ямар сохортлоо л уйлав гэж дээ.

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....
- 5.....

Алхам 2. Эхэд буй онцолж тодруулсан өгүүлбэрийг шалтгааны утгат холбох үгээр нэмэн дэлгэрүүлж хувиргаж бичээрэй. Эхийн утга санаа хэрхэн өөрчлөгдөв. Эргэцүүлэн бодоорой.

Үлгэрлэвэл: Дэлгэр зун ажил өрнүүн, ургац арвин. Дэлгэр зунаар ургах нарнаас, жаргах наран хүртэл зогсолтгүй ажиллаж хөдөлмөрлөсөн учраас ургац арвин, таатай сайхан байна. гэх мэт.

Сайн малчны баясгалан

Хатуу өвөл, хавсарган хавар, дэлгэр зун, баян намрын дөрвөн цагийн дотор дутагдал гачигдалгүй өнгөрөөж, дөрвөн зүг, найман зохист таван төрөл мал бэлчиж, баян монголын сайн малчны баярын магнай тэнилгэнэ. **Хатуу өвөлд хашаа саравчтай сэтгэл амар. Хавсарган хаварт хадлан бордоотой санаа төвшин. Халуун зун худаг устай бодлого тайван. Баян намарт жин хөсөгтэй амьдарлага сайхан.** Ийм жаргалтай малчныг сайн малчин гэх бөгөөд түүний баян өргөн орших нь сайн малчны баясгалан ажээ. (Д.Нацагдорж)

- Хатуу өвөлд хашаа саравчтай сэтгэл амар.
- Хавсарган хаварт хадлан бордоотой санаа төвшин.....
- Халуун зун худаг устай бодлого тайван.....
- Баян намарт жин хөсөгтэй амьдарлага сайхан.....

Дууссан:онсарөдөр

Эхийг шалтгаан үр дагаврын холбоогоор дэлгэрүүлэн найруулж бичих

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 5. Тоочин дүрсэлсэн эхийг уншаад, цэгийн оронд орхисон өгүүлбэрүүдийг учир шалтгааныг тайлбарласан өгүүлбэр болгон хувиргана уу. Эхийн утга санаа хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Үлгэрлэвэл: Хүний хань ажлын тэнхээ – номхон морьд газар эх шиг ээлтэй. Үүний учир монголчууд хүлэг морио дээдлэн хайрлаж ирсэн уламжлалтай. гэх мэт

Морьд

Морьд янз бүр. Хүнтэй адил өөр өөр. Хурдан морь их үсэргээнд өнгөтэй. Эрдмийн гараанд жигдэрсэн оюутан залуус мэт жавхаалаг. Жороо морь олны нүдэнд чимэгтэй. Хурц тод ухаант яруу найрагчийн төрхтэй. Ажлын морь тэнхлүүн чийрэг, ачаанд зүтгэх нь сул яваа юм шиг чөлөөтэй. Амаргүй бүхнийг нуга дарсан ажилчин хүний байдалтай. Хонины морь номхон усгал зантай. Ажил нар хоёрт ивээгдсэн малчин эцгийн дүртэй. Нүдний баясал сэтгэлийн хийморь, хурдан жороо морьд тэнгэрийн од шиг өнгөлөг. Хүний хань ажлын тэнхээ – номхон морьд газар эх шиг ээлтэй. Морьд янз бүр хүнтэй адил өөр өөр. (Л.Мөнхтөр)

Морьд

Морьд янз бүр. Хүнтэй адил өөр өөр. Хурдан морь их үсэргээнд өнгөтэй.

Учир нь.....

Жороо морь олны нүдэнд чимэгтэй. **Яагаад гэвэл**

Ажлын морь тэнхлүүн чийрэг, ачаанд зүтгэх нь сул яваа юм шиг чөлөөтэй. **Учир юун гэвэл**.....

Хонины морь номхон усгал зантай. **Иймийн тул**

Нүдний баясал сэтгэлийн хийморь, хурдан жороо морьд тэнгэрийн од шиг өнгөлөг. Хүний хань ажлын тэнхээ – номхон морьд газар эх шиг ээлтэй. Морьд янз бүр хүнтэй адил өөр өөр.


Дууссан:онсарөдөр

Шалтгаан үр дагаврын холбоо бүхий эх зохион бичих

Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 6: Учир шалтгааныг тайлбарласан бичил эх (цогцолбор) зохиож бичнэ үү. Цогцолбор нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхлэл суурь өгүүлбэр. Гол эхлэл хэсгийг дэлгэрүүлэн тайлбарласан өгүүлбэр. Төгсгөл дүгнэлт өгүүлбэр. **Үлгэрлэвэл:**



Дууссан:онсарөдөр

Өөрийн болон багшийн үнэлгээний зураглал. IX анги



Бүлэг сэдэв: Учир шалтгааныг тайлбарласан эх:


№	Эзэмших чадвар	Эхэлсэн	Дууссан	Өөрийн үнэлгээ (+ тэмдгээр)			Багшийн үнэлгээ
1	Учир шалтгааныг тайлбарласан эхийг задлан шинжилж унших						
2	Шалтгааны утгат холбох үг, нөхцөлийг таних, хэрэглэх						
3	Шалтгаант нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих						
4	Шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих						
5	Эхийг шалтгаан үр дагаврын холбоогоор дэлгэрүүлэн найруулж бичих						
6	Шалтгаан үр дагаврын холбоо бүхий эх зохион бичих						

Бүлэг сэдэв: Дэвшүүлсэн асуудал, баримт, үзэл бодол, дүгнэлт

Дэвшүүлсэн асуудлыг тодорхойлох

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Хэрэв асуудлаа дэвшүүлсэн бол үзэл бодлоо илэрхийлж, түүнийгээ баримтаар нотолж дүгнэлт гаргана. Үзэл бодлоо хэчнээн ч өгүүлбэрээр дэлгэрүүлэн илэрхийлж болно.

Надад таалагдаж байна


Хэлэх зорилго, үгийн өнгө аясыг үл авцалдуулан үгийн байвал зохих орныг эс олбол, адилтгаваас хувцасаа тохируулж өмсөөгүй мэт болох буюу. Аливаа хэлэнд хүндэтгэсэн буюу дээд, ерийн буюу дунд, доршоосон буюу доод түвшний найруулга гэж байдаг. Өнөө бидний өдөр тутмын хэл ярианд буруу хэлж бичиж буйгаа үл ухаарах болсон нийтлэг зуршил бишгүй байдгийн нэг нь “өөртөө үгийн томдсон малгай өмсгөсөн” **“таалагдах”** гэдэг үгийн хэрэглээ юм. Эх хэлний боловсрол, мэдрэмж дутуугийн харгайгаар эл хүндэтгэсэн үгийг ерийн үгийн адил хэрэглэсээр нэгэнтээ уджээ.

Энэ үгийн үндэс нь дур сонирхол гэсэн утгат “таа” хэмээх үг бөгөөд “таатай, таагүй, тааваар, таашаах, таалал, таалах, тааламж, таарах” гэх мэт олон үг үүсжээ. Эдгээрийн дотроос “таалал, таалах, таалагдах” гэсэн үгийг монгол бичгийн хэлнээ тэнгэр бурхан хийгээд ихэс дээдсийн тухайд зөвхөн хүндэтгэлийн үгийн үүргээр хэрэглэж ирсэн уламжлалтай. Энэчлэн “таалал гажих” (дээдэс дургүйлхэх, үл болгоох), “таалалд нийцүүлэх” (дээдийн аяыг дагах), “таалал төгсөх” (хутагт хувилгаад нас барах), “тогтоосон таалал” (дээрээс болгоон тогтоосон зүйл) гэх мэт хэллэг буй. Иймд “надад таалагдаж байна” гэсэн өгүүлбэр нь “Би айлдъя”, “Би зооглоё”, “Миний мэлмий”, “Миний нас сүүдэр төдий зэрэгцлээ”, “Миний алдар нэр”, “Эрхэм хүндэт миний лагшин” гэх мэтээр өөрөө өөртөө хүндэтгэлийн үг хэрэглэсэнтэй чанар адил юм. Найруулгынх нь үүргийг нягтлалгүй, үгийг зохисгүй газар хэрэглэх өөр олон хандлага газар авч буйг сэргэж анхаараасай. (М.Баярсайхан)

Дасгал 1. Дэвшүүлсэн асуудлыг тодорхойлъя.

Алхам 1. Өгүүлэгчийн шүүмжилсэн санаа бүхий 5 холбоо үгийг эхээс ялгаж бичнэ үү.

Шүүмжилсэн санаат үг хэллэг



Алхам 2. Алхам 1 дээрх үгсийг нэгтгэн дүгнэсэн санааг илэрхийлсэн өгүүлбэрийг эхээс ялгаж бичнэ үү.

.....
.....
.....

Алхам 3.

Өгүүлэгч юунд шүүмжлэлтэй хандсан бэ?

.....
.....

Ямар асуудал дэвшүүлсэн байна вэ?

.....
.....

Дууссан:онсарөдөр

Баримт, үзэл бодол, дүгнэлтийг тодорхойлох

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 2. Баримт, үзэл бодол, дүгнэлтийн уялдаа холбоог тодорхойлъё.



Баримт: Өгүүлэгчийн үзэл бодлыг нотлох боломжтой үнэн бодит, сонирхолтой, эх сурвалж нь найдвартай, итгэл үнэмшил төрүүлэхүйц хэрэглэгдэхүүн байна.

Үзэл бодол: Баримт сэтгэгдэл хоёрын завсарт орших бөгөөд мэдлэг, мэдээлэл дээрээ тулгуурлан оюун дүгнэлт хийхийг хэлнэ.

Дүгнэлт: Өгүүлэгч нь аливаа асуудлын талаар үзэл бодол болон баримтад тулгуурлан нотолж баталж гаргасан оюун дүгнэлт чухал байдаг. Голдуу асуудал дэвшүүлсэн эхийн төгсгөлд асуудлыг олон талаас эргэцүүлэн бодож, шүүн тунгааж үндэслэлтэй дүгнэлт гаргахыг эрмэлзэнэ. Дүгнэлт нь хувь хүний дэвшүүлсэн асуудлын шийдэл байх нь бий.

Алхам 1. Эхээс “Таа” язгуурт үгийн тухай 2 төрлийн баримтыг ялгаж бичнэ үү.


Баримт 1
Баримт 2

Алхам 2. Дээрх хоёр баримтыг ямар зорилгоор сонгосон байна вэ? Товч тайлбар бичнэ үү.

.....
.....
.....

Алхам 3. 2 дугаар догол мөрд өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг тодруулж будаарай.

Алхам 4. Цэгийн оронд өгүүлэгчийн үзэл бодол ба баримтын ялгаатай шинжүүдийг тоочиж бичнэ үү.



Алхам 5. Эхээс дараах хэсгүүдэд тохируулан, тус бүр нэг холбоо үг олж бичнэ үү.

	Дэвшүүлсэн асуудал	}	?
	Үзэл бодол		
	Шийдэл санал		

Алхам 6. Сонголтот даалгавар. а. б. хоёр хэсгийн аль нэгийг сонгож дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, дүгнэлтийн уялдаа холбоог бичнэ үү. Чамд аль нь илүү ойлгомжтой, хялбар санагдаж байна вэ? а. Өгүүлэгч:

	гэсэн асуудлыг дэвшүүлээд
	гэсэн үзэл бодлоор дэмжиж
	гэсэн шийдэл санал гаргаж дүгнэжээ.

б. Эхийн хэсгүүдийн уялдаа холбоог дүгнэнэ үү.

Өгүүлэгч уг эхэд баримт ба үзэл бодлоо гэсэн холбож санаагаа илэрхийлжээ.

Түүнчлэн

гэсэн асуудлыг дэвшүүлж

..... гэсэн дүгнэлт гаргаж,

.....байхыг сануулжээ.

Дууссан:онсарөдөр

Баримтад үндэслэн санаагаа илэрхийлэх

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 3. Баримтад үндэслэн тайлбарлан бичье.

Алхам 1. Баримтуудыг доорх эхийн тохирох хэсэгт зөв байрлуулж бичээрэй.

Баримт1. Энэ киноны тухай “Los Angeles Times” сонины кино шүүмжлэгч Кеннетт Туран “Кино наадмын хамгийн гайхалтай бүтээл, хамгийн сонирхол татсан түүх энд байна.

Баримт 2. Беллтэй хамт зураглаач Симон Ниблетт тэргүүтэй таван хүн хамт явж, тэд гурван сарын турш Монголд ажиллахдаа 1500 метр кабель утас “S1000” дрон, 60 метрийн урт кран ашигласан аж.

Баримт 3. Энэхүү баримтат киног найруулсан Отто Белл “Би олон жил богино хэмжээний кинон дээр ажилласан. Ямар гайхалтай түүх олох гэж Уганда, Египет, Япон, Вьетнам гээд сонирхолтой орнуудаар аялсан бэ. Харин яг хайж байсан зүйлээ Монголоос олсон доо.” хэмээн нээлтийн үеэр яриад “Ашер Свиденскийн авсан Айшолпаны гэрэл зургуудыг интернэтээр харсан даруйдаа гайхалтай баримтат кино болно доо гэж мэдсэн.

Баримт 4. Бүргэдчин охин Айшолпаны түүхээр бүтээсэн “The Eagle Huntress” баримтат кино өнгөрсөн ням гарагт “Sundance” олон улсын томоохон кино наадмын үеэр нээлтээ хийж, багагүй шуугиан тариад байна.

Баримт 5. Айшолпан охин “Сандэнс” кино наадмын үеэр “The Eagle Huntress” киноны албан ёсны нээлтэд оролцохоор Америкийг зорьсон бөгөөд хэвлэлийн бага хуралд оролцож, киног нь олон улсад гаргах эрхийг худалдан авах сонирхолтой байгаа компаниудын төлөөлөлтэй уулзсан тухай “Los Angeles Times” – т дурдсан байна.

Барууныхан түүнийг зөвхөн эрчүүд ноёрхож ирсэн 2000 жилийн уламжлалыг эвдсэн, залуу охидод үлгэр дуурайл болох баатарлаг түүх бүтээсэн хэмээн шагшиж, кино наадамд өрсөлдөж буй бүтээлүүдээс үзэгч, шүүмжлэгчдийн анхаарлыг хамгийн их татаж буй аж.

Монголын баатарлаг түүхийг дэлхий мэднэ. Гэхдээ үүнийг харин хэн ч мэдэхгүй.” хэмээн бичжээ.

Ингэхдээ тэр өөрийн хайртай бүргэд Аккатнат буюу “Цагаан даль” – аа дагуулан явжээ.

Тэгээд гэрэл зурагчинтай яаралтай холбогдож, хаягийг нь заалгаад, шуудхан л Монгол руу ниссэн.” гэжээ.


Уг киног олон улсад гаргах компани “Сандэнс”- ээс олдох магадлал өндөр байгаа бөгөөд “Star Wars: The Force Awakens” киноны залуу од, залуу жүжигчин Дэйзи Ридлей ерөнхий продюсераар нь ажиллахаар болсон бол алдарт дуучин, Грэммийн шагналт Сия уг баримтат киноны дуу “Angel by The Wings” – ийг зохиож, өөрөө дуулжээ. (“Гэрэг” сэтгүүл 2016.02.03 №4)

Өөрийн үнэлгээ:

Бүлэг сэдэв: Дэвшүүлсэн асуудал, баримт, үзэл бодол, дүгнэлт

№	Эзэмших чадвар	Эхэлсэн	Дууссан	Өөрийн үнэлгээ (+ тэмдгээр)			Багшийн үнэлгээ
				😊	😄	😌	
1	Дэвшүүлсэн асуудлыг тодорхойлох						
2	Баримт, үзэл бодол, дүгнэлтийг тодорхойлох						
3	Баримтад үндэслэн санаагаа илэрхийлэх						

Өөрийн үнэлгээний зураглал:



9 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ БИЕ ДААН СУРАЛЦАХ АЖЛЫН ДЭВТРИЙН ЗАМЫН ЗУРАГЛАЛ: Танин мэдэхүйн түвшнээр					
Бүлэг сэдэв	Ажлын хуудас	Ажлын хуудасны дугаар	Танин мэдэхүйн түвшин		
			Мэдэх, ойлгох	Задлан шинжлэх	Үнэлэх, бүтээх
Учир шалтгааныг тайлбарласан эх	Учир шалтгааныг тайлбарласан эхийг задлан шинжлэх	1			
	Шалтгааны утгат холбох үг, нөхцөлийг таних, хэрэглэх	2			
	Шалтгаант нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих	3			
	Шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих	4			
	Эхийг шалтгаан үр дагаврын холбоогоор дэлгэрүүлэн найруулж бичих	5			
	Шалтгаан үр дагаврын холбоо бүхий эх зохион бичих	6			
Дэвшүүлсэн асуудал, баримт, үзэл бодол, дүгнэлт	Дэвшүүлсэн асуудлыг тодорхойлох	1			
	Баримт, үзэл бодол, дүгнэлтийг тодорхойлох	2			
	Баримтад үндэслэн санаагаа илэрхийлэх	3			
	Бүлэг сэдвийн үнэлгээ дүгнэлт	1 – 2			